



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/188-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БҮХТ	Боловсролын үнэлгээний хөгжлийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СҮХБААТАР СУМЫН 4 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.БАЯРЖАРГАЛ ТАНАА

2023.02.25 № СЗА-2023/188-НА-СТА-ТШЗ

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 99.8 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 229.6 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 955.2 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсөв 0.2 хувиар хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 67.5 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 12.5 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байна.

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/343 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 7,495.5 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	74,132,677.36	88,596,924.53
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,235,537.71
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,235,537.71
31210	Төгрөг	-	1,235,537.71
31211	Төрийн сангийн харилцах	-	1,235,537.71
33	АВЛАГА	344,400.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	344,400.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	73,788,277.36	87,361,386.82
35400	Хангамжийн материал	73,788,277.36	87,361,386.82
35410	Бичиг хэргийн материал	174,400.00	-
35420	Аж ахуйн материал	72,995,677.36	85,720,966.82
35460	Хүнсний материал	-	838,920.00
35470	Бусад хангамжийн материал	618,200.00	801,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,171,273,943.57	1,104,469,078.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,171,273,943.57	1,104,469,078.84
39200	Биет хөрөнгө	1,119,636,943.65	1,053,144,578.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,234,606,149.00	1,234,606,149.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(229,533,852.34)	(259,495,590.10)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	102,872,225.19	102,872,225.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,087,812.43)	(63,607,060.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,174,944.55	82,174,944.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,264,897.67)	(52,123,414.91)
39209	Зам, гүүрийн байгууламж	882,240.00	882,240.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(220,560.12)	(294,080.16)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,756,321.00	6,489,450.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(547,813.53)	(747,154.80)
39217	Ном	-	2,386,871.00
39300	Биет бус хөрөнгө	51,636,999.92	51,324,499.88
39301	Програм хангамж	2,021,100.00	2,021,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,396,100.08)	(1,708,600.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	51,012,000.00	51,012,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,245,406,620.93	1,193,066,003.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	60,839.00	50.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	60,839.00	50.00
41300	Өглөг	60,839.00	50.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	60,839.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	50.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,245,345,781.93	1,193,065,953.37
51	Засгийн газрын хувь оролцоо	1,245,345,781.93	1,193,065,953.37
51100	Засгийн газрын оруулсан капитал	318,281,669.42	318,281,669.42
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	318,281,669.42	318,281,669.42
51200	Хуримтлагдсан үр дүн	633,778,242.24	581,498,413.68
51210	Өмнөх үеийн үр дүн	622,245,756.82	(611,283,978.69)
51220	Тайлант үеийн үр дүн	11,532,485.42	1,192,782,392.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	293,285,870.27	293,285,870.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,245,406,620.93	1,193,066,003.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	621,621,234.26	1,991,767,762.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,115,113.26	1,245,591,220.93
120	Нийтлэг татварын бус орлого	43,115,113.26	1,245,591,220.93
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	42,129,258.18	1,171,273,943.57
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	985,855.08	74,317,277.36
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	578,506,121.00	746,176,542.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	514,586,600.00	598,879,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	598,879,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	514,586,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	270,000.00	1,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	270,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,600,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,649,521.00	145,697,142.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,649,521.00	145,697,142.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	610,088,748.84	798,985,370.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	610,088,748.84	798,985,370.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	601,066,861.42	792,613,270.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	388,766,201.58	446,078,275.62
210101	Үндсэн цалин	286,208,943.68	336,245,138.91
210102	Нэмэгдэл	75,783,990.33	99,000,616.04
210104	Урамшуулал	26,773,267.57	10,832,520.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,633,173.00	55,958,069.67
210201	Тэтгэврийн даатгал	37,023,675.52	38,419,930.37
210202	Тэтгэмжийн даатгал	3,939,704.62	4,513,319.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,124,923.71	3,566,980.13
210204	Ажилгүйдлийн даатгал	2,995,862.53	856,969.92
210205	Эрүүл мэндийн даатгал	5,549,006.62	8,600,869.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,649,521.00	92,795,926.00
210301	Гэрэл, цахилгаан	4,026,730.00	5,083,644.00
210302	Түлш, халаалт	53,225,930.00	79,820,586.00
210303	Цэвэр, бохир ус	6,396,861.00	7,891,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,487,619.26	4,947,710.54
210401	Бичиг хэрэг	167,100.00	138,400.00
210402	Тээвэр, шатахуун	367,500.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	397,300.00	-
210404	Ном, хэвлэл	9,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,996,850.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	548,895.54	-
210408	Бараа материал акалсны зардал	7,000,973.72	4,809,310.54
2105	Нормативт зардал	28,326,377.00	97,113,024.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	109,900.00	-
210502	Хоол, хүнс	28,155,277.00	97,113,024.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	61,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,015,000.00	15,500,000.00

210604	Урсгал засвар	3,015,000.00	15,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	192,100.00	-
210702	Дотоод албан томилолт	192,100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,694,700.00	1,227,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	722,700.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,227,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,302,169.58	78,992,964.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,690,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,546,300.00	2,377,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,755,869.58	68,924,864.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,021,887.42	6,372,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	6,372,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,372,100.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,021,887.42	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,021,887.42	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	11,532,485.42	1,192,782,392.37
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	11,532,485.42	1,192,782,392.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	578,506,121.00	746,176,542.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	578,506,121.00	746,176,542.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	514,586,600.00	598,879,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	598,879,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	514,586,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	270,000.00	1,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	270,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,600,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,649,521.00	145,697,142.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,649,521.00	145,697,142.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	569,714,421.00	742,821,004.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	569,714,421.00	742,821,004.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	560,692,533.58	736,448,904.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	389,919,629.58	446,476,825.29
210101	Үндсэн цалин	287,362,371.68	336,643,688.58
210102	Нэмэгдэл	75,783,990.33	99,000,616.04
210104	Урамшуулал	26,773,267.57	10,832,520.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,563,206.00	55,520,109.00
210201	Тэтгэврийн даатгал	35,953,708.52	37,981,969.70
210202	Тэтгэмжийн даатгал	3,939,704.62	4,513,319.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,124,923.71	3,566,980.13
210204	Ажилгүйдлийн даатгал	2,995,862.53	856,969.92
210205	Эрүүл мэндийн даатгал	5,549,006.62	8,600,869.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,649,521.00	92,795,926.00
210301	Гэрэл, цахилгаан	3,135,738.00	5,083,644.00
210302	Түлш, халаалт	53,225,930.00	79,820,586.00
210303	Цэвэр, бохир ус	7,287,853.00	7,891,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,070,100.00	100,000.00
210401	Бичиг хэрэг	188,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	367,500.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	527,300.00	-
210404	Ном, хэвлэл	45,000.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,103,900.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	838,400.00	-
2105	Нормативт зардал	41,648,477.00	97,951,894.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	119,900.00	-
210502	Хоол, хүнс	28,267,377.00	97,951,894.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,261,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,015,000.00	23,500,000.00
210604	Урсгал засвар	3,015,000.00	23,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	192,100.00	-
210702	Дотоод албан томилолт	192,100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,694,700.00	1,356,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	722,700.00	-

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,356,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,939,800.00	18,748,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,108,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,939,800.00	4,640,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,021,887.42	6,372,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	6,372,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,372,100.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,021,887.42	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,021,887.42	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,791,700.00	3,355,537.71
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8,791,700.00	2,120,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,791,700.00	2,120,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,791,700.00	2,120,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,791,700.00	2,120,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(8,791,700.00)	(2,120,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	1,235,537.71
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,235,537.71

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	318,281,669.42	293,285,870.27	(611,283,978.69)	283,561.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	(611,283,978.69)	283,561.00
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,192,782,392.37	1,192,782,392.37
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	581,498,413.68	1,193,065,953.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	744,576,800.00	743,341,004.29	1,235,795.71	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	744,576,800.00	743,341,004.29	1,235,795.71	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	739,704,700.00	743,341,004.29	(3,636,304.29)	100.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	446,462,200.00	446,232,675.29	229,524.71	99.9
210101	Үндсэн цалин	366,466,200.00	336,399,538.58	30,066,661.42	91.8
210102	Нэмэгдэл	70,196,800.00	99,000,616.04	(28,803,816.04)	141.0
210104	Урамшуулал	9,799,200.00	10,832,520.67	(1,033,320.67)	110.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,520,200.00	55,520,109.00	91.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	37,753,700.00	37,981,969.70	(228,269.70)	100.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,441,600.00	4,513,319.97	(71,719.97)	101.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,553,300.00	3,566,980.13	(13,680.13)	100.4
210204	Ажилгүйдлийн даатгал	888,400.00	856,969.92	31,430.08	96.5
210205	Эрүүл мэндийн даатгал	8,883,200.00	8,600,869.28	282,330.72	96.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,796,000.00	92,795,926.00	74.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	5,083,600.00	5,083,644.00	(44.00)	100.0
210302	Түлш, халаалт	79,820,600.00	79,820,586.00	14.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	7,891,800.00	7,891,696.00	104.00	100.0
2105	Нормативт зардал	98,907,000.00	97,951,894.00	955,106.00	99.0
210502	Хоол, хүнс	98,907,000.00	97,951,894.00	955,106.00	99.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,500,000.00	23,500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	23,500,000.00	23,500,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,406,000.00	1,356,000.00	50,000.00	96.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,406,000.00	1,356,000.00	50,000.00	96.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,113,300.00	21,112,300.00	1,000.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,113,300.00	15,112,300.00	1,000.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,872,100.00	4,872,100.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,872,100.00	4,872,100.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,872,100.00	4,872,100.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	744,576,800.00	744,576,542.00	258.00	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	598,879,400.00	598,879,400.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	598,879,400.00	598,879,400.00	-	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	145,697,400.00	145,697,142.00	258.00	100.0
320001	Орон нутгийн төсвөөс	145,697,400.00	145,697,142.00	258.00	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,235,537.71	(1,235,537.71)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	325	257	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	33	33	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12	-	100.0

620003	Үйлчлэх ажилтан	20	20	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	258	190	-	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	258	190	-	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	258	190	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	33	33	-	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	33	33	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь “Танин мэдэх хэрэгцээнд тулгуурласан сургалтын баялаг орчин бүрдүүлж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэнд – идэвхтэй хөдөлгөөн, зөв дадал хэвшлийг эзэмшүүлэх,
- Эерэг төлөвшил,
- Таатай орчин – чөлөөт сонголт, бүх талын хөгжлийг хангах бодит орчин,
- Эерэг харилцаа – хайр халамж, эелдэг дотно харилцаа, баяр хөөрийг цогцлооно.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг

төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,

- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болох БШУЯ-ны зүгээс дотоод аудит, хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн

талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52,340.6 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		1,235.5	1,235.5
Авлага	344.4		(344.4)
Бараа материал	73,788.3	87,361.4	13,573.1
Үндсэн хөрөнгө	1,171,273.9	1,104,469.1	(66,804.8)
Нийт хөрөнгө	1,245,406.6	1,193,066.0	(52,340.6)
Өр төлбөр	60.8		(60.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,245,345.8	1,193,066.0	(52,279.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,245,406.6	1,193,066.0	(52,340.6)

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 1,235.5 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 87,361.4 мянган төгрөг болж 13,573.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 135,170.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Э.Наранцэцэгээс 529.0 төгрөгийн тоглоом үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 122,126.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,482,445.0 мянган төгрөг болж 2,120.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,120.0 мянган төгрөгийн хөгжмийн зэмсэг худалдан авснаас шалтгаалсан байна.

Өмнөх оны 60.8 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулж өр төлбөр данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,193,066.0 мянган төгрөг болж 52,279.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 538,489.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 158,998.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 697,488.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, НДШ-ийн зардлыг 49,079.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 16,852.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж нийт төсвийг 631,556.6 мянган төгрөгөөр баталсан байна.

2022 оны 12 дугаар сард хийсэн төсвийн зохицуулалтаар цалин хөлс, НДШ-ийн зардлыг 23,144.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 18,196.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 37,774.2 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 23,000.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,033.3 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 4,872.1 мянган төгрөгөөр нэмснээр улсын төсвөөс 598,879.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 145,697.4 мянган төгрөг нийт 744,576.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 598,879.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 145,697.4 мянган төгрөг нийт 744,576.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 743,341.0 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 229.5 мянган төгрөг, хоолны зардлаас 955.1 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардлаас 50.0 мянган төгрөгийг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,900.0	1,899.0	1.0	99.9
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	98,907.0	97,951.9	955.1	99.0
		3	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,401.9	2,401.9	-	100.0
		4	81823- Боловсролын багшийн сургалт	1,900.0	1,900.0	-	100.0
		5	81834- Боловсролын стандарт сургалт	424,915.9	424,865.9	50.0	100.0
		6	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	68,854.6	68,625.2	229.4	99.7
		7	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	116,296.0	116,295.9	0.1	100.0
		8	80112- Нийтлэг үйлчилгээ	29,401.4	29,401.2	0.2	100.0
		Нийт		744,576.8	743,341.0	1,235.8	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн аудитор А.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 610,088.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,100.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх НДШ, үдийн цай хөтөлбөр, сургалт семинарын зардлаас нийт 1,235.5 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн

агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд боловсролын байгууллагын мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроосон 2 мэдээллийг мэдээлээгүй бөгөөд мэдээллийн хэрэгжилт 98.0 хувьтай байна.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн боловч бүрэн хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой мэдээллийг 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Дараа жилийн төсвийн төсөлтэй холбоотой мэдээллийг 1 удаа мэдээлээгүй
- Байгууллагын батлагдсан төсөвтэй холбоотой 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.6, 6.2.2, 6.2.3, 6.2.6, 6.3.1, 6.3.3, 6.3.4, 6.3.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онд гаргасан зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 02-ны 22/49 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн цахим баримттай холбоотой 99,263.0 мянган төгрөгийн зөрчил, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн боловч алдаа зөрчил давтагдан гарснаар зөвлөмжийн 50.0 хувийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	180.3	1	180.3	100.0
Албан шаардлага					
Зөвлөмж	2	100,397.7	1	1,134.4	50.0
Нийт дүн	3	100,578.0	2	1,314.7	66.6

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхааран авч үзэх нь зүйтэй. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан, хяналт тавьж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлтэй байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх

нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

4. Хэдийгээр мах, гурил, хүнсний ногоо болон бусад материал зэрэг олон нэр төрлийн хүнсний материал худалдан авч байгаа ч гэсэн худалдан авалтын гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж байх нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт **4,490.3** мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж 1 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс **4,490.3** мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй	1	4,490.3			1	4,490.3							
Дүн	1	4,490.3			1	4,490.3							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл хоцроосон	1	-			1	-		
Огт мэдээлээгүй	2	-			2	-		
Дүн	3	-			3	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	3	-			3	-		